УМЭАЦТЛ-ийн захирлын 2025 оны А/28 дугаар тушаалаар “Дотоод аудит хийх тухай” удирдамж, хөтөлбөрийг баталсан байна. Удирдамжийн хүрээнд Эпидемиологи, эрсдэлийн шинжилгээ, мониторинг мэдээллийн нэгж нь MNS ISO/IEC 17025 стандартын хэрэгжилт, лабораторийн хэвийн үйл ажиллагааг хянах, үр дүнг нэгтгэн ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори УТҮГ нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/385 дугээр тушаалаар баталсан “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөн ажиллаж байгаа боловч холбогдох хууль тогтоомж, журмын шинэчлэл өөрчлөлтийг бодлогын баримт бичигт тухай бүр тусгаагүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт, үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори УТҮГ нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 894,270.5 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт* *[/мянган төгрөгөөр/]*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 111,224.7 | 316,671.5 | 205,446.8 |
| Бараа материал | 1,706,001.5 | 1,829,710.4 | 123,708.9 |
| Үндсэн хөрөнгө | 5,876,386.3 | 6,441,501.1 | 565,114.8 |
| **Нийт хөрөнгө** | **7,693,612.5** | **8,587,883.0** | **894,270.5** |
| Өглөг | 2,131.5 | 384,015.4 | 381,883.9 |
| Засгийн газрын хувь оролцоо/ Эздийн өмч/ | 7,691,481.0 | 8,203,867.6 | 512,386.6 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **7,693,612.5** | **8,587,883.0** | **894,270.5** |

Авлага дансны үлдэгдэл 316,671.5 мянган төгрөг болж, 205,446.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд өмнөх оны санхүүжилтийн 110,199.7 мянган төгрөгийн авлагыг барагдуулж, ажиллагсдаас авах авлага 20.6 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 2,046.0 мянган төгрөг, тайлант онд татаас санхүүжилтийн 314,604.9 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулж, тайлагнаснаас шалтгаалжээ;

Бараа материалын дансны үлдэгдэл 1,829,710.4 мянган төгрөг болж, 123,708.9 мянган төгрөгөөр өссөн нь МЭЕГ-аас тендер шалгаруулалтаар 1,127,303.3 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан, 589,057.5 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авсан, лабораторийн оношилгоо, шинжилгээ, тандалтад 1,581,869.9 мянган

төгрөгийн материалыг зарцуулсан, орон нутгийн 21 аймаг, нийслэлд 14,319.2 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгсэл болон оношлуур үнэ төлбөргүй шилжүүлсэн нь нөлөөлсөн; Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 6,441,501.1 мянган төгрөгт хүрч өссөн нь Жайка олон улсын байгууллагын "Төрийн болон хувийн хэвшлийн малын эмч нарын практик чадавхыг бэхжүүлэх" төслийн хүрээнд сургалтын өрөөнд 409,127.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж хандив, МЭЕГ-аас нээлттэй тендер шалгаруулалтаар 441,864.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг балансаас балансt шилжүүлэн авч, ТӨБЗГ-ын 2025 оны 36 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг 2,417,785.4 мянган төгрөгөөр дахин үнэлж бүртгэж нэмэгдүүлсэн. ТӨБЗГ-ын 2025 оны 45 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 180,440.1 мянган төгрөгийн хөрөнгийн акталж, данс бүртгэлээс хасаж, 1,383,548.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон байна;

Өр төлбөрийн үлдэгдэл 384,015.5 мянган төгрөг болж, 381,883.9 мянган төгрөгөөр өссөн нь тус лабораторийн “Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр хэрэгжүүлэх” арга хэмжээний 21,481.0 мянган төгрөг, “Малын архаг халдварт өвчнөөс эрүүлжүүлэх” зардлын 191,425.9 мянган төгрөг, “Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх” 120,149.9 мянган төгрөг, “Малын архаг халдварт өвчнөөс эрүүлжүүлэх” арга хэмжээний 73,225.9 мянган төгрөг, нийт 4 хөтөлбөр арга хэмжээний санхүүжилтийн зарцуулах эрхийг нээгээгүйтэй холбоотой;

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 512,386.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлан оны үр дүнгээс шалтгаалсан байна.

Тус лабораторийн биет бус хөрөнгийн дансанд Дижитал Медик ХХК-ийн лабораторийн цахим систем (http://sur.shinjilgee.mn) нь андройд, IOS ухаалаг гар утсанд суурилан ажилладаг бөгөөд судалгааг цаасаар авдаг уламжлалт аргыг хялбарчилж асуумж, судалгаа авах үйл явц, мэдээллийг цуглуулах, дамжуулах хугацааг хурдасгахад чиглэсэн программын төлбөр 9,990.0 мянган төгрөг, Дата ланд технологи ХХК ХААХҮЯам төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа газруудын OpenGov төсвийн нэгдсэн систем (https://auth-mofa.opengov.mn/login), Хас эрин орчил ХХК-ийн vet.dynamic.mn онлайн санхүүгийн программ бүртгэлтэй, тайлант онд программын үйлчилгээний төлбөр 880.0 мянган төгрөгийн төлбөрийг төлсөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлт, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус лабораторийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,483,797.6 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 552,594.4 мянган төгрөг, нийт зарлагыг 4,036,392.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 906,633.5 мянган төгрөгийн эд хогшил, урсгал засвар, малын архаг халдварт өвчин болон гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх, харуул хамгаалалтын зардлуудыг тус тус бууруулж 3,129,758.5 мянган төгрөгөөр баталсан.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,132,767.8 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 828,074.9 мянган төгрөг, нийт 2,960,842.8 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал зардалд 2,685,362.2 мянган төгрөгийг зарцуулж, өөрийн орлогын 275,480.6 мянган төгрөгийг улсын төсвийн санхүүжилтийн авлагаар бүртгэсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,685,362.2 мянган төгрөг буюу 85.8 хувь байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 57,843.2 мянган төгрөг, лабораторийн итгэмжлэл 1,122.3 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж , урамшуулал дэмжлэгийн зардлыг 6,147.7 мянган төгрөг, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх зардлыг 21,481.1 мянган төгрөг, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зардлыг 120,150.0 мянган төгрөг, малын архаг халдварт өвчнөөс эрүүлжүүлэх зардлыг 164,426.0 мянган төгрөг, мал амьтан эрүүлжүүлэх зардлыг 73,226.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой.

| Хөтөлбөр, арга хэмжээний код, нэр | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 70801 | | Мал аж ахуйг хөгжүүлэх | 3,129,758.5 | 2,685,362.2 | 444,396.3 | 85.8 |
| 1 | 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 2,406,221.1 | 2,348,377.9 | 57,843.21 | 97.6 |
| 2 | 80219 | Харуул,хамгаалалтын зардал | 13,828.9 | 13,828.9 | - | 100.0 |
| 3 | 80227 | Лабораторийн итгэмжлэл | 7,941.4 | 6,819.1 | 1,122.3 | 85.9 |
| 4 | 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг | 6,547.7 | 400.0 | 6,147.7 | 6.1 |
| 5 | 81569 | Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх | 88,728.0 | 67,246.9 | 21,481.1 | 75.8 |
| 6 | 82506 | Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх | 169,672.4 | 49,522.4 | 120,150.0 | 29.2 |
| 7 | 82507 | Мал архаг халдварт өвчнөөс эрүүлжүүлэх | 253,964.2 | 89,538.2 | 164,426.0 | 35.3 |
| 8 | 82548 | Мал, амьтан эрүүлжүүлэх | 182,855.0 | 109,629.0 | 73,226.0 | 60.0 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Мал Эмнэлгийн Ерөнхий Газрын даргын 2022 оны А/62 дугаар тушаалаар 2 нэгж, 4 лаборатори, 52 орон тоотой байхаар бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийсэн.

Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 153 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Мал эмнэлгийн ерөнхий газрын харьяа 2 лабораторийг нэгтгэн “Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори” УТҮГ, “Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори” УТҮГ-т нэгтгэн “Улсын мал эмнэлэг, ариун цэвэр, эмийн сорилт, баталгаажуулалтын нэгдсэн лаборатори” УТҮГ болгон өөрчлөн зохион байгуулахаар , чиг үүргийн давхардлыг арилгах, дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг батлах тухай шийдвэр гарсан байна.

Лабораторийн захирлын 2025 оны А/01 дүгээр тушаалаар албан тушаалын зэрэглэл, цалин, төрийн албаны нэмэгдэл, нэг ажилтанд ногдох өдрийн хоолны мөнгө 25.0 мянган төгрөг, унааны зардал 3.0 мянган төгрөг олгохоор баталж тайлант онд хоол, унааны хөнгөлөлтөд нийт 262,734.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тайлант хугацаанд гадаад томилолт 16,099.3 мянган төгрөг, дотоод томилолт 75,475.5 мянган төгрөг, “Команд штабын сургууль” сургалтыг 1,188.0 мянган төгрөгөөр зохион байгуулсан, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний зардал гараагүй, төрд учирсан хохирлын төлбөрийн асуудал байхгүй байна.

**3.5.3 Нэмэлт төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар БНСУ-ын Амьтан ургамлын хорио цээрийн газартай хамтарсан “Монгол улсад эргэлдэж байгаа шүлхийн вирусийн генетикийн шинжилгээний ба судалгаа” хамтын төсөл, “Монгол улсад эргэлдэж байгаа галзуу өвчний түргэн тест турших төсөл, БНСУ-ын Ванконгийн их сургуультай хамтарсан “Шувууны томуу”

хамтын төсөл нийт 231,875.2 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 5,000.0 мянган төгрөг, нийн 236,875.0 мянган төгрөгийн орлого бүрдсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн орлогоос төслийн гэрээт ажлын хөлсөнд 46,607.9 мянган төгрөг, эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэлд 39,299.8 мянган төгрөг, томилолтод 46,409.0 мянган төгрөг, багаж, техникт 41,276.0 мянган төгрөг, урсгал зардал болон бусад зардалд 24,044.5 мянган төгрөг, нийт 197,637.2 мянган төгрөгийг зарцуулж, 39,238.0 мянган төгрөгийг санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус лабораторийн ХАА-ны төлөвлөгөөг 756,452.4 мянган төгрөгөөр баталж, 589,057.5 мянган төгрөгийн худалдан авалтыг зохион байгуулж ажилласан байна.

Мал, амьтны гоц халдварт, халдваргүй өвчин, оношилгоо тандалтын хэрэглэгдэхүүн худалдан авах УМЭАЦТЛ/20250102001 дугаартай нээлттэй тендерийг 2025 оны 09 сарын 08 өдөр цахим сайтад байршуулсан байна. Тендер шалгаруулалтаар Монветмэд ХХК шалгарч, гэрээг 2025 оны 10 дугаар сарын 13 өдөр 349,745.8 мянган төгрөгөөр байгуулсан. Бичиг хэрэг, хангамжийн зардал 220,172.3 мянган төгрөг, түлш тослох материалын 19,139.4 мянган төгрөг, нийт 239,311.7 мянган төгрөгийн шууд худалдан авалтыг зохион байгуулсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн УТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт стандарт болон хуулийн өөрчлөлтийг тусган шинэчлэх, хөрөнгийн тооллогыг чанартай гүйцэтгэх, тайлант хугацааны бараа материал, хөрөнгийн хөдөлгөөний бүртгэлийг тооллогын бүртгэлтэй тулган баталгаажуулахтай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Ашид баланс Аудит” ХХК-ийн Ахлах аудитор Д.Алтанцэцэг, аудитор Т.Баясгалан, туслах аудитор Б.Доржсүрэн нар гүйцэтгэж, аудитын менежер Л.Оюунчимэг, захирал Л.Майцэцэг нар анхан шатны хяналтыг, Санхүүгийн аудитын газрын Ахлах аудитор П.Батцэцэг, Аудитын менежер Э.Энхбаатар, газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц,Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг ҮАГ болон Ашид баланс Аудит ХХК-д 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийлсэн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 7,123,266.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцож 71,232.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалт, шаардлага горимын дагуу төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1. Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 3 авто тээврийн хэрэгслийн улсын дугаарыг тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар солих ажлыг зохион байгуулах талаар өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", Төрийн хэмнэлтийн тухай

хуулийн 6 дугаар зүйлийн 6.4" төрийн болон орон нутгийн өмчит бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 3 авто тээврийн хэрэгслийн улсын дугаарыг тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар солих ажлыг зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор нь аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 151 мэдээллээс 149 мэдээллийг хугацаанд байршуулж, 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, үндсэн хөрөнгө, мөнгөн хөрөнгө, бараа материал, нийгмийн даатгалын өглөгийн данстууд болон өмнөх зөвлөмж, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулан, асуудлын бүртгэлээр баталгаажуулж 200,823.1 мянган төгрөгийн 1 алдааг залруулсан.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 1,238.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 12,106.2 мянган төгрөгийн зөрчил арилгах 1 албан шаардлага, 10,500.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгснийг нотлох баримтад үндэслэн хянаж үнэлэхэд 100.0 хувийн биелэлттэй бүрэн биелсэн байна.

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 1,238.5 | 1 | 1,238.5 | 100 |
| Албан шаардлага | 1 | 12,106.2 | 1 | 12,106.2 | 100 |
| Зөвлөмж | 3 | 36,778.4 | 2 | 36,778.4 | 66.7 |
| **Нийт дүн** | **5** | **50,123.1** | **4** | **50,123.1** | 88.9 |

Нийцлийн аудитын асуудлаар 26,278.4 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсний худалдан авах ажиллагааг үндэслэлтэй төлөвлөөгүй, төлөвлөгөөнд тусгаагүй худалдан авалтыг гүйцэтгэсэн 26,278.4 мянган төгрөгийн албан шаардлагын биелэлт хэрэгжсэн, байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 3 авто тээврийн хэрэгслийн улсын дугаарыг тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар солих ажлыг зохион байгуулаагүй 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу Засгийн газрын finperform.mof.gov.mn санхүүгийн программаар 2025 оны санхүүгийн тайлан бэлтгэхэд программын шинэчлэлт жигдрээгүй, тайлан баталгаажуулахад хүндрэлтэй байлаа.
2. Засгийн газрын 2025 оны 153 дугаар тогтоолоор “Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори” улсын төсөвт үйлдвэрийн газрыг “Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори” улсын төсөвт үйлдвэрийн газарт нэгтгэн “Улсын мал эмнэлэг, ариун цэвэр, эмийн сорилт, баталгаажуулалтын нэгдсэн лаборатори” улсын төсөвт үйлдвэрийн газар болгон өөрчлөн зохион байгуулах, чиг үүргийн давхардлыг арилгах, дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, мөрдүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад үүрэг болгосон байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 299,455.8 мянган төгрөгийн 3 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

*Залруулсан алдаа:*

- Сангийн яамны татаас санхүүжилтийн авлага 275,480.6 мянган төгрөгийг дутуу бүртгэсэн. УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, санхүүгийн тайлагналын “Оршин байх”, “Эрх ба үүрэг”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй;
- Нийгмийн даатгалын оны эхний үлдэгдэл 949.7 мянган төгрөгийн өглөгийг нийгмийн даатгалын авлага хаасан бичилтийг үр дүнгийн тайланд оруулж тайлагнасан УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, санхүүгийн тайлагналын “Оршин байх”, “Эрх ба үүрэг”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй;
- Лабораторийн тоног төхөөрөмж шилжүүлэх шийдвэр гараагүй байхад 23,025.5 мянган төгрөгийг хасаж тайлагнасан нь УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, санхүүгийн тайлагналын “Оршин байх”, “Үнэн зөв бай”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 28,894.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 616.0 мянган төгрөгийн төлбөрийн 1 акт тогтоож, 28,278.6 мянган төгрөгийн зөрчлийн арилгах 2  албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

1. Нэр бүхий ажилчдад томилолтын хугацаанд хоол, унааны хөнгөлөлтөд 616.0 мянган төгрөгийг давхардуулан олгож, зардал өсгөсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах",  6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Давхардуулж олгосон хоол, унааны мөнгө 616.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх.

### 5.3 Албан шаардлага

1. Зардлын эдийн засгийн ангилал хооронд цалингийн зардлаас татварын зардал 15,786.6 мянган төгрөг, нийгмийн даатгалын 12,492,0 мянган төгрөг, нийт 28,278.6 төгрөгийг шилжүүлэн тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах",  6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 22 дугаар зүйлийн 22.5-т "Төсвийн ангиллын зүйлд санаатайгаар буруу мэдээлэл оруулж төсвийн орлого, зарлагын хэмжээг өөрчлөхийг хориглоно", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Зардлын эдийн засгийн ангиллыг зориулалтын дагуу бүртгэж тайлагнаагүй  зөрчлийг таслан зогсоох.

**5.4 Зөвлөмж**

**1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* ХХААХҮС-ын 2019 оны А/385 дугаар тушаалаар батлагдсан НБББББ-г шинэчлэн боловсруулаагүй нягтлан бодох бүртгэлтэй холбоотой хуулийн заалт, журам аргачлал нь хүчингүй болсон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2."Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, заавapт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2 "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг стандарт болон хуулийн өөрчлөлтийг тусган, төсвөөс нэмэлт зардал гаргахгүйгээр өөрсдийн нөөц бололцоогоор шинэчлэх

**2. Бараа материал, хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* Жилийн эцсийн хөрөнгийн тооллогын тасалбар болгосон хугацаанаас хойш МЭЕГ-аас шилжүүлсэн бараа материал, үндсэн хөрөнгийг тооллогын бүртгэлд тусгаагүй, тооллогын бүртгэлийн дүн нь тайланд тусгасан бараа материалын дүнгээс 393,677.6 мянган төгрөг, үндсэн хөрөнгийн дүнгээс 461,739.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1-д "Үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн тооллогоор бэлэн байгаа үлдэгдэл, нягтлан бодох бүртгэлээр байвал зохих үлдэгдлийн хоорондын зөрүүг дор дурдсан журмаар тохируулан тооцно", 73.2-т "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Хөрөнгийн тооллогыг чанартай гүйцэтгэж, тооллогын тасалбар болгосон хугацаанаас хойших хөрөнгийн хөдөлгөөнийг тооллогод бүрэн хамруулах, нягтлан бодох бүртгэлээрх дүнтэй тулган баталгаажуулж, тайлагнаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье!

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| № | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Сангийн яамны татаас санхүүжилтийн авлага дутуу тусгасан | 1 | 275,480.6 | | | | | 1 | 275,480.6 | | | | |
| 2 | Нийгмийн даатгалын өглөг 949.7 мянган төгрөгийг авлагын дансанд хаасан бичилтийг үр дүнгийн тайланд оруулж тайлагнасан байна. | 1 | 949.7 | | | | | 1 | 949.7 | | | | |
| 3 | Лабораторийн тоног төхөөрөмж шилжүүлэх шийдвэр гараагүй байхад хасаж тайлагнасан | 1 | 23,025.5 | | | | | 1 | 23,025.5 | | | | |
| | Дүн | 3 | 299,445.8 | | | | | 3 | 299,445.8 | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо |
| 1 | Зардлын эдийн засгийн ангилал хооронд татварын зардал 15,786.6 мянган төгрөг, нийгмийн даатгалын 12,492.0 мянган төгрөг, нийт 28,278.6 мянган төгрөгийг шилжүүлэн тайлагнасан байна. | 1 | 28,278.6 | | | 1 | 28,278.6 | | | | |
| 2 | Нэр бүхий ажилчдад томилолтын хугацаанд хоол, унааны мөнгө давхардуулж олгож зардал өсгөсөн | 1 | 616.0 | 1 | 616.0 | | | | | | |
| 3 | Жилийн эцсийн хөрөнгийн тооллогын тасалбар болгосон хугацаанаас хойш гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн хөдөлгөөнийг тооллогын бүртгэлд тусгаагүй, тооллогын бүртгэлийн дүн санхүү байдлын тайланд тусгагдсан бараа материал 393,677.6 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 461,739.9 мянган төгрөг нийт 855,740.9 мянган төгрөгөөр зөрүүтэй дутуу илэрхийлэгдсэн байна. | 1 | | | | | | 1 | | | |
| 4 | 2019 онд батлагдсан НББББ-г шинэчлэн боловсруулаагүй нягтлан бодох бүртгэлтэй холбоотой хуулийн заалт, журам аргачлал нь хүчингүй болсон байна. | 1 | | | | | | 1 | | | |
| | **Дүн** | **4** | **28,894.6** | **1** | **616.0** | **1** | **28,278.6** | **2** | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | |
| 1 | Өмнөх аудитаар өгсөн байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 3 авто тээврийн хэрэгслийн улсын дугаарыг тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар солих ажлыг зохион байгуулаагүй зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. | 1 | | 1 | | | |
| | Дүн | 1 | | 1 | | | |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр    Дугаар 478/А0150079    Улаанбаатар хот

САГ-2026/234/ИА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зардлын эдийн засгийн ангилал хооронд цалингийн зардлаас татварын зардал 15,786,632.86 (арван таван сая долоон зуун наян зургаан мянга зургаан зуун гучин хоёр төгрөг, наян зургаан мөнгө), нийгмийн даатгалын 12,491,955.28 (арван хоёр сая дөрвөн зуун ерэн нэгэн мянга есөн зуун тавин таван төгрөг, хорин найман мөнгө), нийт 28,278,588.14 (хорин найман сая хоёр зуун далан найман мянга таван зуун наян найман төгрөг, арван дөрвөн мөнгө) төгрөгийг шилжүүлэн тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, 6.4.8 *"төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"*, 22 дугаар зүйлийн 22.5 *"Төсвийн ангиллын зүйлд санаатайгаар буруу мэдээлэл оруулж төсвийн орлого, зарлагын хэмжээг өөрчлөхийг хориглоно"*, 41 дүгээр зүйлийн 41.2.2 *"батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах"*, 41.2.7 *"хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах"*, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр *"Ангилал шинэчлэн батлах тухай"* журмын хавсралт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 *"нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах"* гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө."*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 *"хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"* гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зардлын эдийн засгийн ангиллыг зориулалтын дагуу бүртгэж тайлагнаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн захирал /Ө.Гэрэлмаа/, ерөнхий нягтлан бодогч /Д.Байгалмаа/ нарт даалгав

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР    Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР    Э. ЭНХБААТАР
АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ    Л.МАЙЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-76.Docx

1526180943

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АКТ**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 97/А0150079 Улаанбаатар хот

САГ-2026/234/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэр бүхий ажилчдад томилолтын хугацаанд хоол, унааны мөнгө 616,000.00 (зургаан зуун арван зургаан мянган) төгрөгийг давхардуулж олгож, зардал өсгөсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө."*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3 "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Давхардуулж олгосон хоол, унааны мөнгө 616,000.00 (зургаан зуун арван зургаан мянган) төгрөгийг ерөнхий нягтлан бодогч /Д.Байгалмаа/-аар төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан дах Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн захирал /Ө.Гэрэлмаа/-д даалгав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР Э. ЭНХБААТАР

АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Л.МАЙЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Akt\2026\0225 SAG-50.Docx

1526160546

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 479/А0150079 Улаанбаатар хот

САГ-2026/234/ИА-СТА-ТШ3

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 3 авто тээврийн хэрэгслийн улсын дугаарыг тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар солих ажлыг зохион байгуулаагүй зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 *"Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно"*, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 *"төрийн болон орон нутгийн өмчит бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ"* гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө."*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.10 *"аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол"* гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 3 авто тээврийн хэрэгслийн улсын дугаарыг тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар солих ажлыг зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн захирал /Ө.Гэрэлмаа/, ерөнхий нягтлан бодогч /Д.Байгалмаа/ нарт даалгав

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Э. ЭНХБААТАР
АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Л.МАЙЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-76.Docx

1526180945